

**ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ҮНДЭСНИЙ ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх ажил/арга хэмжээ	Хэрэгжсэн хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Биелэлт	Тайлбар
1.	Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах	2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг АТГ-д хүргүүлэх	2014.03.01	ЭБАТ Тамгын газрын дарга Э.Одбаяр	ХТҮГ-ын даргын 2013 оны А/57 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, албан хаагчдын дотоод мэдээлэл-сургалтын цагаар авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөний төсөлд албан хаагчдаас санал авч боловсруулалтыг эцэслэсэн.
		Төлөвлөгөөг албан хаагчдад танилцуулах, үүрэг даалгавар хүлээлгэх	2014.03.07	ЭБАТ Тамгын газрын дарга Э.Одбаяр /Ц.Номин/	Хүүхдийн төлөө үндэсний газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөний дагуу шууд үүрэг хүлээсэн 15 албан хаагчид үүрэг даалгавар хүлээлгэсэн бөгөөд гүйцэтгэлийг хангалттай биелүүлсэн.
		Авлигагүй хамт олон байх уриалгыг олон нийтэд мэдэгдэх	2014.03.12	Олон нийттэй харилцах хэлтэс Н.Оюунчимэг /Г.Ундрах, Х.Даваадорж/	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын талбарт төрийн болон иргэний нийгэм, төрийн бус, олон улсын байгууллагын 1000 гаруй албан тушаалтан, ажилтан, албан хаагчидтай байнгын харилцаа холбоотой ажилладаг бөгөөд түншлэгчдэдээ хандаж авлига, ёс зүйн зөрчилгүй, хүүхэд хамгааллын бодлоготой ажиллах мэдэгдэл гаргаж, www.nac.gov.mn сайтад байршуулж ажиллуулсан.
		Төлөвлөгөө хэрэгжилтийн мэдээллийг улирал бүр АТГ-т хүргүүлэх	Улиралд	ЭБАТ Тамгын газрын дарга Э.Одбаяр	Төлөвлөгөөний биелэлт тайлант хугацааны улирал бүр 15-20 хувийн гүйцэтгэлтэйгээр тогтвортой биелэгдэн хэрэгжсэн.
2.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах	УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын дагуу урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө орлогын	2014.02.20	ЭБАТ Тамгын газрын дарга Э.Одбаяр /Г.Ундрах/	Нийт албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж, нэгтгэл тайлан мэдээг АТГ-т хүргүүлж хянуулан ажиллаж хэвшсэн.

	мэдүүлгийг заасан хугацаагаар мөрдүүлэн хэвшүүлэх			Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах ажлын байр/албан тушаалд нэр дэвшсэн 10 хүний урьдчилсан мэдүүлгийг АТГ-ын холбогдох нэгж, албан тушаалтнаар хянуулж сул орон тоог нөхөх ажиллагаа зохион байгуулсан.
	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх замаар албан ажлаар бусад байгууллагад хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажиллах албан хаагчдын жагсаалтыг урьдчилан гаргаж батлуулан, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах	Жилд	ЭБАТ Тамгын газрын дарга Э.Одбаяр /Б.Давхарбаяр/, /Д.Бямбацогт/	Олон улсын хүүхдийн “Найрамдал” төв, Монгол улсын хүүхэд гэр бүл хөгжлийн “Өнөр бүл” төв, ХТҮГ-т явагдах засвар, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд оролцох, хяналт тавих чиг үүрэг бүхий 8 албан хаагчийг АЗ лицэнз олгох сургалтанд хамруулснаар 5 албан хаагч шаардлага хангасан. Тайлант хугацаанд нэр бүхий 3 байгууллагад 18 удаагийн тендер, худалдан авалтын ажиллагаа журмын дагуу алдаа, зөрчилгүй явагдсан. Тендер, худалдан авах ажиллагааг дараахь ажлын байрны чиг үүрэгт хамааруулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Тендерийн асуудлыг, төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэнд • Худалдан авах ажиллагааны асуудлыг, нийтлэг үйлчилгээний хэлтсийн даргад
	ХТҮГ-ын цахим хуудсаар дамжуулан байгууллагын, албан хаагчдын чиг үүрэг, үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллуулах	Жилд	ЭБАТ Тамгын газрын дарга Э.Одбаяр /Н.Оюунчимэг/, /Г.Алтансүх/	ХТҮГ-ын www.nac.gov.mn сайтны ил тод байдлын хүний нөөц хуудсанд байгууллагын албан хаагчдын чиг үүрэг, үйл ажиллагааны мэдээллийг байршуулсан. Сайт, facebook хуудсанд хандсан сэтгэгдлүүдийг хэлэлцдэг болсон.
3.	“Хүүхэд хамгааллын бодлого” баримт бичгийг www.nac.gov.mn цахим хуудсанд байршуулж, нийтээр дагаж мөрдөх хэрэгжилтийг өөрийн үнэлгээгээр хянаж	Жилд	ЭБАТ Тамгын газрын дарга Э.Одбаяр /Б.Жавзанхүү/	2014 оноос хэрэгжүүлж эхэлсэн хүүхэд хамгааллын бодлогыг нийтээр дагаж мөрдөж байгаатай холбогдуулан агентлагийн дотоодод явцын хяналт шинжилгээ, үнэлгээ

	ажиллах			/Д.Мөнхчулуун/	хийх удирдамж боловсруулж бэлтгэл хангаж байна.
4.	Шинээр боловсруулж буй хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийт, сонирхогч бүлгээр хэлэлцүүлэх, тэдний саналыг тусгах	“Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Гэр бүлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл олон нийтийн санал авах ажил хэргийн уулзалтыг үе шаттай зохион байгуулах	II улирал	Хуулийн зөвлөгөө, өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн	“Гэр бүлийн тухай”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн шинэчилсэн найруулга, шинэ төсөл боловсруулахад ХАХНХЯ, олон нийттэй хамтарч 20 удаагийн хэлэлцүүлгээр 2000 гаруй хүүхэд, иргэдээс санал авсан. Тайлант хугацаанд ХАХНХ, ХЗДХ-ийн сайдаар уламжлагдан “Гэр бүлийн тухай” хуулийн төсөл УИХ-д, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн төсөл Засгийн газарт өргөн баригдсан. “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн үзэл баримтлал, төслийн танилцуулгыг www.nac.gov.mn сайтны баримт бичиг хуудсанд байршуулав.
		Хуулийн шинэчилсэн найрууллага, нэмэлт өөрчлөлтийн тухай төслийг төслийг веб хуудсаар дамжуулан сонирхогч бүлэг, олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах	III улирал	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын нэгжийн дарга нар	
5.	Төсвийн орлого, түүний зарцуулалтыг, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг вебсайтад байршуулах	Байгууллагын 2014 оны төсөв	2014.01.10	Ерөнхий нягтлан бодогч Г.Ганням	Байгууллагын www.nac.gov.mn сайтны ил тод байдал хуудсанд төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны бүх мэдээллийг хугацааны дагуу байршуулсан. Энэхүү чиглэлийн асуудлаар олон нийтээс санал, хүсэлт гараагүй болно.
		2013 оны төсвийн гүйцэтгэл	2014.04.03		
		2015 оны төсвийн төсөл	2014.09.15		
		2013 оны санхүүгийн тайлан	2014.04.03		
		2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Тухай бүр		
		2014 онд НҮБ ХС,	2014.03.20		

		ДЗ ОУБ, НЛМ ОУБ-тай хамтарч ажиллах төлөвлөгөөг АТГ-т хүргүүлэх		ОУ-ын хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Д.Хишгээ /З.Өнө-Ундрах, Нэгжийн дарга/	“Хүүхдийн эрх, хөгжил 2” төсөл батлагдсан бөгөөд хамтын үйл ажиллагааны гэрээ хийгдэх хугацаа болоогүй байна. Монгол улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн хооронд байгуулсан 2012-2016 оны хамтын ажиллагааны гэрээг Шадар сайд үзэглэсэн бөгөөд жилийн хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд агентлагийн дарга гарын үсэг зурсан. “108-хүүхдийн тусламжийн утас”-ны дуудлагын төв ажиллуулах хамтарсан төсөл хэрэгжүүлэх Санамж бичигт ХТҮГ, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, Мобиком компанийн удирдах ажилтнууд гарын үсэг зурсан.
		“Хүүхдэд ээлтэй орон нутаг Санаачлага”, “Хүүхэд хамгаалал”, “Дотуур байран дах хүүхдийн эрх, хөгжил”, “Хамтарсан багийн мэргэшүүлэх сургалт” зэрэг төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг вебсайтад байршуулах	Тухай бүр		НҮБ-ын Хүүхдийн сангийн техникийн дэмжлэгтэй “Хүүхдэд ээлтэй орон нутаг, хүүхэд хамгаалал, мэдээлэл мониторинг, нөлөөлөл сурталчилгаа” төслийн хэрэгжилтэд 276 749 062 төгрөг зарцуулсан. Дэлхийн зөн олон улсын байгууллын санхүүгийн дэмжлэгтэй “хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал, хүүхэд хамгааллын багц судалгаа, 108 - хүүхдийн тусламжийн утас”-ны үйлчилгээний хэрэгжилтэнд 20 619 050 төгрөг зарцуулсан. Нэр бүхий төслийн үйл ажиллагааг нэгжийн дарга /Ж.Долгормаа, Б.Жавзанхүү, Д.Мөнхчулуун, Н.Оюунчимэг/ нар хариуцан зохион байгуулав. Гүйцэтгэлээр нийт 297 368 112 төгрөг зарцуулсан.
6.	Чиг үүргийн дагуу олгож буй	Хүүхдэд зориулсан асрамж, халамж,	Зөвшөөрөл олгосноос	Хүүхэд хамгааллын	Өнчин, харж хандах хүнгүй, гэр орноосоо дайжсан, үл хайхралт, хүчирхийлэл,

	зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэл танилцах боломжийг хангах	хамгааллын үйлчилгээ эрхэлдэг төвүүдэд тусгай зөвшөөрөл олгосон тухай байгууллагын мэдээллийг вебсайтад байршуулсан, баяжилт хийх	хойш 10 өдөрт багтаах	эрсдэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Г.Ойнбаяр /И.Мөнгөнтулга/	мөлжлөгт өртсөн хүүхдэд асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ эрхлэх зориулалтаар иргэн, хамт олон, байгууллага, төсөл, хөтөлбөрийн хүрээнд 29 зөвшөөрөл ХТҮГ-ын даргын шийдвэрээр олгогдож, 1300 хүүхэд үйлчилгээнд хамрагдаад байна. Зөвшөөрөл авсан байгууллагын жагсаалтыг байгууллагын www.nac.gov.mn сайтны хүүхэд хамгаалал хуудсанд байршуулсан. Хүүхдүүдийн бүртгэл www.hub.com програмд байршсан байдаг.
7.	Хүний нөөцийн ил тод нээлттэй байдлыг хангах	Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөхөх ажиллагааг ХАХНХЯ-ны салбар зөвлөлөөр дамжуулан шийдвэрлэх	Тухай бүр	Төрийн захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Ундрах	ХТҮГ-ын төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо /хүүхдээ асрах чөлөө эдэлж байгаа албан хаагчийн/-г нөхөх ажиллагааг ХАХНХЯ-ны төрийн албаны салбар зөвлөлийн нөөцөд бүртгэлтэй 10 иргэнийг сонгон шалгаруулж туршилтын хугацаатай ажиллуулж байна.
		Тайлант хугацаанд томилогдсон албан тушаалтны жагсаалт, ажил үүргийн чиглэлийн жагсаалт гаргаж АТГ-д хүргүүлэх	2014.03.10		Тайлант хугацаанд томилогдсон албан тушаалтны болон ажил үүргийн чиглэлийн жагсаалт гаргаж /ХТҮГ-ын 2014.03.01-ны өдрийн/ албан бичгээр АТГ-т хүргүүлсэн.
		Албан хаагчдын чиг үүрэг, олон нийттэй харилцах уулзалтын хуваарийг вебсайтад байршуулах	2014.03.14		ХТҮГ-ын болон аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн албан хаагчдын хариуцсан чиг үүрэг, иргэд шууд хандах утасны дугаарын жагсаалт, олон нийттэй харилцах, хүлээн авах уулзалтын хуваарийг www.nac.gov.mn сайтын ил тод байдал хуудсанд байршуулсан.

8.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	Худалдан авах ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, вебсайтад байршуулах	2014.04.03	Хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Б.Давхарбаяр /Э.Одбаяр Т.Түвшин Б.Бурмаа/	ХТҮГ-аас зохион байгуулсан суудлын автомашин худалдан авах тендерийн урилгыг “Өглөөний сонин”-ы 2014 оны 02 дугаар сарын 20 өдрийн 033 дугаарт, мөн www.e-procurement.mn сайтад байршуулсан. Тоёота лексус 470 маркын автомашин авч, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн ажлын албаны орон нутгийн хэрэгцээнд ашиглаж байна.
		Худалдан авах ажиллагааны 2015 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, вебсайтад байршуулах	2014.12.15		
		Шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл холбогдох албан тушаалтанд хүргүүлэх	Тухай бүр		Худалдан авах ажиллагаанд шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийн СЯ, ХАХНХЯ, ХААГ-ын холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.
		Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан, тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх	Тухай бүр		
		Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад дүгнэлт болон бусад	Тухай бүр		Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн мөрөөр сайруулах арга хэмжээ авч ажилласан.

		хяналт, шалгалтын дүнгийн мөрөөр арга хэмжээ авч ажиллах			
9.	Төрийн албан хаагч нэг бүрийн хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах, вебсайтад байгаа мэдээлэлд зохих өөрчлөлт оруулах	Тухай бүр	Төрийн захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Ундрах /Х.Даваадорж/	ХТҮГ-ын албан хаагч нэг бүрийн хариуцсан ажил, үүрэгт орсон зохих өөрчлөлт, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аудитын газрын үзлэгээр хянасан мэдээдлийг байгууллагын www.nac.gov.mn сайтын ил тод байдлын "хүний нөөц" хуудсанд байршуулсан.	
10.	Хүүхдийн аливаа асуудлаар хэрэгждэг үндэсний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хүүхэд, эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг хамтран гүйцэтгэх: "Шударга хүүхэд-2014" судалгаа	2014.09.22	Хүүхэд, гэр бүлийн хбгжлийн мэргэжилтэн Б.Ариунтуяа И.Мөнгөтулга Л.Ариунтунгалаг Г.Ойнбаяр	2014 онд НҮБ-ын "Хүүхдийн эрхийн тухай" конвенцийн хэрэгжилтийн талаарх Үндэсний 5 дугаар илтгэл боловсруулж НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээхтэй холбогдуулан хүүхэд хамгааллын багц 4 төрлийн судалгаа, нээлттэй хаалганы "Хүүхдээ сонсоё" асуумжид 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 10,000 гаруй хүүхэд, олон нийт, эцэг, эхчүүд оролцож хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлаарх бодлогын хэрэгжилтэд санал, сэтгэгдлээ ирүүлсэн. АТГ-аас зохион байгуулдаг "Шударга хүүхэд-2014" судалгаанд тус газар хамтран ажилласан.	
11.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	Дүрмийн төслийг боловсруулж АТГ-аас санал авах	2014.04.05	ЭБАТ Тамгын газрын дарга Э.Одбаяр /Г.Ундрах/	2013 онд батлан мөрдөж байгаа ХТҮГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 2.2., 4.13., 4.14., 5.2., 7.2., 7.3., 8.1., 9.5.4. заалтуудад авлигатай холбоотой асуудлыг төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хүрээнд авч үзэж тусгасан бөгөөд 2015 оноос мөрдөх журмын нэмэлт өөрчлөлтөнд албан хаагч ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3
		Дүрмийг батлах, нийт албан хаагчдад танилцуулах	2014.04.18		
		Хэрэгжилтэд хяналт тавих, энэ талаар АТГ-т тайлагнах	Жилд		


					заалт нэмж тусгаад байна. Мөн шинээр ажилд орж байгаа иргэнийг албан тушаалд томилохдоо төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийг тушаалын заалтаар албан хаагчид хариуцуулдаг хэвшил тогтсон.
12.	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, давхар ажил эрхлэх зөвшөөрлийг олгох, давхар ажил эрхлэлтийн судалгаа гаргах		Тухай бүр	Төрийн захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Ундрах	Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих замаар гэр бүл, нийгмийг хөгжлийн таатай орчин болгоход чиглэсэн мэдээлэл, нөлөөллийн хамтын ажиллагааг өргөжүүлэх гэх мэт үйл ажиллагааны стратеги бүрийг хэрэгжүүлэхэд 43 орон тоогоор ажиллах шийдвэртэй боловч улсын төсвөөс 34 орон тоо зөвшөөрснөөр ачаалалтай ажилладаг тул албан хаагчид давхар ажил эрхлэх боломж нөхцөл бүрдээгүй.
13.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах	Жилд	ЭБАТ Тамгын газрын дарга Э.Одбаяр	Олон улсын байгууллагуудтай хамтарсан зорилтот хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн, төрийн бус байгууллагаас 2 удаа зөвлөх үйлчилгээ, гэрээлэн гүйцэтгэх (судалгаа, сурталчилгаа, хэвлэл мэдээллийн нэвтрүүлэг, баримт бичгийн боловсруулалт г.м) ажлууд хийгдсэн. Авлигад өртөх эрсдэл үүсээгүй.
		Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх	Жилд		Албан тушаалын чиг үүрэгтэй хамааралтай ашиг сонирхлын зөрчил албан хаагчдад үүсээгүй. ХТҮГ-ын дарга, төсвийн шууд захирагчийн манлайллын зорилтын хэрэгжилтийн үр дүнд “авлигагүй хамт олон” үнэлэмжээ энэ онд хэвээр хадгалсан.
	Авлигын эрсдэл ба	Тухай бүр	Албан хаагч болон нэгж бүрээр 7 хоногийн		

		авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах			ажлын тайлан гаргаж байгууллагын хэмжээнд нэгтгэх явцдаа авлигын эрсдэл ба авлига гарах нөхцөлд ажиглалт, хяналт тогтмол хийгддэг.
14.	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар АТГ-т нэн даруй мэдээлэх		Тухай бүр	ЭБАТ Тамгын газрын дарга Э.Одбаяр	Тайлант хугацаанд авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчил бүхий асуудал гараагүй.
15.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	АТГ-аас ирүүлсэн зөрчил, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, хариуцлага тооцож, арга хэмжээ авах, Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр, дүрэм, журам, зааврыг өөрчлөх буюу хүчингүй болгох, АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах зэрэг зөвлөмжийг хэрэгжүүлэх	Тухай бүр		АТГ-аас ирүүлсэн албан бичгийн хариуг хуулиар тогтоосон хугацаанд гүйцэтгэж хариу хүргүүлж ажилласан. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.16 дахь заалт болон авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийг хүртээмжтэй байлгах, үйл ажиллагаагаа нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах тухай АТГ-аас өгсөн зөвлөмжүүдийг байгууллагын дотоодын мэдээллийн сүлжээнд хавтас нээж байршуулан албан хаагчид үйл ажиллагаандаа хэрэглэх нөхцлийг бүрдүүлсэн, зөвлөмж хэрэгжилтийг хангуулж ажилласан. 2014 онд тус байгууллагад зөрчил, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулах санал, зөвлөмж АТГ-аас ирээгүй.
16.	Байгууллагын удирдлагын	Авлигагүй хамт олон, байгууллага	2014.04.04	Тамгын газрын дарга Э.Одбаяр	Төсвийн шууд захирагч болон нэгжийн менежерүүд "авлигатай тэмцэх хүсэл

авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх	байх эрмэлзлэлээ олон нийтэд нээлттэй мэдэгдэх		/Г.Ундрах/	эрмэлзлэл, хүчин чармайлт"-аа 2014 оны үр дүнгийн гэрээний манлайллын зорилтдоо дэвшүүлж илэрхийлсэн.
	Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх "Санамж"-ийг албан хаагчдад гардуулах ажил зохион байгуулах	2014.03.20	Тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Д.Батзаяа	Авлигын эсрэг хууль тогтоомжийг судлах, хэрэгжүүлэх талаар дотоодын мэдээлэл-сургалтын цагаар 4 удаа танилцуулж, мэдээлсэн. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх "Санамж"-ийг албан хаагчид хүлээн авч хэрэгжүүлсэн.

Тайлагнасан:


Э.Одбаяр



Тамгын газрын дарга, Эрх бүхий албан тушаалтан

Танилцсан:

И.Нарантуяа



Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ҮНДЭСНИЙ ГАЗАР

.....000.....